



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2009

**Энэхүү эмхтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.
Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг-Эрүүл Мэндийн Газар**

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж
Улаанбаатар -210648
Факс: 976-11-320633
Утас: 70111485, 325540
Э-шуудан: admin@doh.gov.mn
www.doh.gov.mn

Редактор: Ц.Содномпил, АҮ-ны доктор (Ph.D)

Эмхтгэсэн: Д.Нямхорол, НЭМ-ийн магистр
Д.Баясгалан, АҮ-ны магистр
С.Ариунтуяа
Т.Өнөрцэцэг

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Уранчимэг
Хэвлэлийн дизайнёр: Ц.Ганганцэцэг

Товчилсон нэр томъёоны тайлбар

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БҮ	Булган
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДГ	Дорноговь
ДО	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
АД	Аймгийн дүн
УБ	Улаанбаатар
УД	Улсын дүн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ДОХ	Дархлалын олдмол хамшинж
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
СТДХ	Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ӨМНӨХ ҮГ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын статистикийн хэлтсээс эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ тайланд тулгуурлан жил бүр эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу тооцож, дүгнэлт хийн эмхтгэл болгон хэвлүүлэж та бүхэнд хүргэдэг.

Бид 2001 оноос эхлэн монгол, англи хэл дээр хэвлүүлэн, 2005 оноос эхлэн эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлтийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар сүүлийн 3 жилээр тооцон гаргаж, эх хүүхдийн эндэгдэл, зарим халдварт өвчний сүүлийн 10 жилийн хандлага, хүн амын өвчлөлийн болон нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг тодорхойлон, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд баяжилт хийн, үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн нийтийн хүртээл болгож байгаа билээ.

2009 оны эмхтгэлд ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд ордог Монгол улсын эрүүл мэндийн салбарын үзүүлэлтүүд, хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг насны бүлэг, хүйс, бус нутгаар тооцож, дэлхийн хүн амын өвчлөл, нас баралтын 2030 он хүртэлх чиг хандлага зэрэг нотолгоонуудыг шинээр оруулж харьцуулсан дүгнэлт хийн хүргэж байна.

2005-2009 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтод хүрсэн үзүүлэлттэй байна.

Бүх түвшний эрүүл мэндийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон мэдээлэл хэрэглэгч бусад хүмүүст нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт бүрэн итгэлтэй байна.

ДАРГА

Ц. СОДНОМПИЛ

Гарчиг

Бүлэг 1. Монгол Улсын хүн ам	6 - 7
1.1 Хүн ам	6
1.2 Хүн амын дундаж наслалт	6
1.3 Монгол улсын хүн ам ба хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд	7
Бүлэг 2. Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд	8 - 11
Бүлэг 3. Эх хүүхдийн эрүүл мэнд	12 - 21
3.1 Эхийн эрүүл мэнд	12
3.1.1 Жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	12-13
3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	14-15
3.1.3 Төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээ	15-16
3.1.4 Хүүхдийн эрүүл мэнд ба хөхөөр хооллолт	16-17
3.1.5 Эхийн эндэгдэл	17-18
3.1.6 Үр хөндөлт	18
3.1.7 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглээ	19
3.2 Хүүхэд өсвөр үеийнхний эрүүл мэнд	19-21
Бүлэг 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ	22 - 31
4.1. Өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	22-24
4.2. Сумын болон сумдын эмнэлгийн тусламж, үйлчилгээ	24-26
4.3. Хоёрдогч шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээ	26-28
4.4 Гуравдагч шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээ	29-31
Бүлэг 5. Томуугийн A(H1N1) вирусийн халдвартын тархалт	32 - 34
Бүлэг 6. Халдварт өвчин	35 - 39
6.1 Нийт халдварт өвчин	35
6.2 Гэдэсний халдвар	36-37
6.3 Амьсгалын замын цочмог халдвар	37-39
6.4 Бэлгийн замаар дамжих халдвар	39
Бүлэг 7. Халдварт бус өвчлөл	40 - 44
7.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	40
Бүлэг 8. Хүн амын нас баралт	45 - 49
8.1 Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт	47
8.2 Хорт хавдрын шалтгаант нас баралт	47
8.3 Гэмтэл хордлого, гадны шалтгаант өвчний нас баралт	48
Бүлэг 9. Эрүүл мэндийн эдийн засаг	50 - 55
9.1 Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд	50
9.2 Эрүүл мэндийн даатгал Хавсралт	51-54 55
Бүлэг 10. ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд орох Монгол улсын үзүүлэлтүүд, 2009	56-60
Бүлэг 11. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, 2009 он	61 - 102

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ


1.1 Монгол улсын хүн ам

Монгол улс нь засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдана. Өнөөдрийн байдлаар Монгол улс нь 21 аймаг, 329 сум, 1564 багтай бөгөөд Улаанбаатар хот нь Монгол улсын нийслэл бөгөөд 9 дүүрэг, 132 хороотой.


2009 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хүн ам 2 сая 735.8 мянгад хүрсэн бөгөөд 2008 онтой харьцуулахад 52.3 мянган хүн буюу 1.9 хувиар ёссэн байна. Нийт хүн амын 62.6 хувь нь хот суурин газар, үлдсэн 37.4 хувь нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хотод 1 сая 112.3 мянган хүн буюу нийт хүн амын 40 хувь нь оршин сууж байна.

Нийт хүн амын 48.9 хувийг эрэгтэйчүүд, 51.1 хувийг эмэгтэйчүүд, насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүхэд 27.6 хувийг, 15- 64 насны хүн ам 68.4 хувийг, 65 дээш насны хүн ам 4.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1.1. 2009 оны дундаж хүн амын тоо, аймгаар



Зураг 1.2 Хот, суурин газар амьдардаг хүн амын эзлэх хувь, аймгаар, 2009



1.2 Дундаж наслалт

Хүний хөгжлийн индексийн үндсэн үзүүлэлтийн нэг болох хүн амын дундаж наслалтаараа Монгол улс хүний хөгжлийн дунд зэргийн хөгжилтэй оронд багтдаг бөгөөд 2009 оны байдлаар хүн амын дундаж наслалт 67.96 байна. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн дундаж наслалт -71.79 эрэгтэйчүүдийн дундаж наслалт -64.33 байна. Эндээс харахад эрэгтэй, эмэгтэй хүн амын дундаж наслалтын хоорондын ялгаа их буюу зөрүү нь 7.5 жил байна

1.3 Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

Монгол улс 1990 оноос хойш хүн ам зүйн шилжилтийн үед байгаа бөгөөд энэ нь төрөлт, нас баралтын түвшин огцом буурч, хүн ам хөгшрөх байдлаар тодорхойлогдож байна. Тухайлбал 1990 онд манай улсын хүн амын дундаж өсөлт 2.7 хувь байсан бол 2000 онд 1.4 хувь, 2003-2005 онд 1.17 болж буурсан. Харин 2007-2009 онд хүн амын өсөлт 1.5-2.0 болж өмнөх 3 жилтэй харьцуулахад 0.3-0.8 -иар нэмэгдсэн байна. Түүнчлэн 1990 онд 1000 хүн амд ногдох төрөлт 35.3 байсан бол 2003 гэхэд 18.0 болж 2 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2004-2006 онд тогтворжин, 2007 онд 21.7, 2008 онд 23.7, 2009 онд 25.30 болж нэмэгдсэн байна.

Нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлсэн хүүхдийн тоо 1990 онд 4.3 байсан бол 2000-2003 онд гэхэд 2 дахин буурсан үзүүлэлттэй байсан. Харин 2007-2009 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ үзүүлэлт нь 2007 онд 2.3, 2008 онд 2.6, 2009 онд 2.7 болж нэмэгдсэн байна.

2009 онд 68762 хүүхэд амьд төрснөөс 2 ихэр хүүхэд 1342 /671 төрөлт/, 3 ихэр хүүхэд 27 /9 төрөлт/ байна. Амьд төрсөн хүүхдийн 51.3 хувь нь эрэгтэй, 48,7 хувь нь эмэгтэй хүүхэд байгаа бөгөөд төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охидод 105 хөвгүүд ногдож байна.

Хүснэгт 1.1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Нийт хүн (мян)	2149.2	2407.5	2504.0	2533.1	2562.3	2594.8	2626.6	2683.5	2735.5
Хотын хүн ам (хувиар)	54.6	57.2	58.5	59.1	60.2	60.9	61.0	61.4	62.6
Хөдөөгийн хүн ам (хувиар)	45.4	42.8	41.5	40.9	39.8	39.1	39.8	38.6	37.4
Насны бүлгээр (хувиар)									
0-15	41.5	33.7	32.6	32.6	32.6	28.6	28.9	28.1	27.6
15-64	54.4	62.8	63.9	63.9	63.9	67.3	67.3	67.8	68.4
65 аас дээш	4.1	3.5	3.5	3.5	3.5	4.1	4.1	4.1	4.0
Хүн ам зүйн коэффициентууд									
ТЕК	35.3	21.5	18.0	17.7	17.8	18.4	21.7	23.7	25.3
НЕК	7.9	5.9	6.1	6.1	6.1	6.1	6.2	5.7	5.7
Цэвэр өсөлт	2.7	1.5	1.2	1.16	1.17	1.23	1.55	1.8	1.9
ТНК	4.3	2.2	2.0	1.9	1.9	1.9	2.3	2.6	2.7

2000 оны хүн амын тооллогын дүнг үндэслэн тооцсон 2000-2025 оны хэтийн тооцоонаас үзэхэд өндөр настны тоо 2005 онд 2000 оныхоос 16.2 хувиар буюу 20.1 мяняган хүнээр, 2010 онд 2000 оныхоос 28.7 хувь буюу 35.6 мянгаар өснө гэсэн тооцоо гарсан байна.

2009 оны байдлаар нийт хүн амын 37.8 хувь нь хөдөө буюу сумын төв, багт амьдарч байна. Өөрөөр хэлбэл нийт хүн амын 40.6 хувь нь УБ хотод, 21.6 хувь нь аймгийн төвд үлдсэн хувь нь хөдөө буюу сумын төв, багт амьдарч байна. 1990 оноос хойш хотжилт, нийгмийн эдийн засгийн хөгжлөө даган хүн ам төв суурин газар руу шилжих хөдөлгөөн буурахгүй байгаагаас 2000 онд нийт хүн амын 42.8 хувь нь хөдөөд оршин суудаг байсан бол 2009 онд 37.8 хувь болж буурсан байна.

БҮЛЭГ 2. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

МХЗ-ыг 2000 оны 9 сард Дэлхийн Мянганы Дээд Хэмжээний Чуулга уулзалтад оролцсон дэлхийн 191 үндэстнийг төлөөлсөн 147 орны төр засгийн тэргүүнүүд баталж, тогтвортой хөгжил, ядууралтай тэмцэх асуудлыг дэлхийн хөгжлийн тэргүүлэх чиглэлээр сонгосноор мянганы хөгжлийн зорилтууд нь аль ч улс орны хөгжил дэвшлийг хэмжих хэмжүүр болж байна.

Монгол улс 2005 онд үндэснийхээ МХЗ-уудыг тодорхойлохдоо хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх асуудлыг МХЗ-уудынхаа салшгүй хэсэг болгож, нийт 9 зорилго 22 зорилтуудыг дэвшүүлэн УИХ-аар батлуулан, хэрэгжилтийг хангахын тулд шаардлагатай бодлого, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол улсын МХЗ-ын хүрээнд хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ХДХВ/ДОХ, сүрьеэ болон бусад өвчинтэй тэмцэх гэсэн эрүүл мэндтэй холбоотой 5 зорилт (7-11 зорилтууд хамаарна) дэвшүүлсэн байдаг.

Зорилт 7

1990-2015 онд нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах

**Хүснэгт 2.1 Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар**

Үзүүлэлт	1990	2000	2004	2005	2006	2007	2008	2009	2015
Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/									
Хүйс									
Эрэгтэй	-	-	25.9	22.8	22.1	19.2	22.4	22.6	
Эмэгтэй	-	-	19.6	18.6	17.3	16.4	16.6	17.6	
Байршил									
Улсын дундаж	63.4	31.2	22.8	20.8	19.8	17.8	19.6	20.2	22.0
УБ хот	70.3	32.8	23.7	18.1	19.0	14.7	17.5	18.0	-
Аймгийн дундаж	62.5	30.8	22.3	22.5	20.3	20.3	21.2	21.9	-
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/									
Хүйс									
Эрэгтэй	-	-	32.5	28.4	26.8	23.3	26.4	25.9	
Эмэгтэй	-	-	25.6	23.6	21.1	20.8	20.2	21.2	
Байршил									
Улсын дундаж	87.5	42.4	29.1	26.1	24.0	22.1	23.4	23.6	29.2
УБ хот	99.9	42.4	28.9	21.7	21.8	18.8	20.8	21.0	-
Аймгийн дундаж	94.4	42.5	29.2	28.9	25.6	24.6	25.3	25.7	-

Сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол улсад нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин тогтвортой буурсныг дээрх статистик тоо мэдээллүүд нотлон харуулж байна. Энэ бууралт нь өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмэнт, хөхөөр хооллолтыг дэмжих зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой юм.

2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн байдал


1990 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхын эндэгдлийн түвшин 63.4 байсан бол 2000 онд гэхэд 2 дахин, 2000-2009 онд 3 дахин буурч, 2009 онд 20.2 болсон байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 87.5 байсан бол 2000 онд гэхэд 2 дахин, 2000-2009 онд 3.7 дахин буурч, 2009 онд 23.6 болсон байна.

Нялхын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин улсын хэмжээгээр 2005-2009 онд 2015 онд дэвшүүлсэн зорилтыг хангасан боловч, аймгуудаар авч үзвэл ялгаатай байна. (Зураг 2.1)

Нялхын эндэгдлийн шалтгаанд перинаталь үеийн эмгэг, амьсгалын болон хоол боловсруулах замын эрхтэн тогтолцооны өвчин, халдварт өвчин, төрөлхийн гажиг, осол гэмтлийн шалтгаант нас бааралт зонхилдог бөгөөд сүүлийн 10 жилд перинатал үеийн болон төрөлхийн гаж хөгжлийн шалтгаант эндэгдэл эрс нэмэгдсэн байна. Тухайлбал 1998 онд нялхын эндэгдлийн шалтгаанд төрөлхийн гажиг 2.0 хувь, перинаталь үеийн эмгэг 25.0 хувийг эзэлж байсан бол 2009 онд төрөлхийн гажиг 11.2 хувь, перинаталь үеийн эмгэг 52.4 хувь болж тус тус нэмэгдсэн байна.

Монгол улсад амьсгал, хоол боловруулах тогтолцооны болон халдварт өвчний шалтгаант хүүхдийн эндэгдэл тогтвортой буурч байгаа боловч нялхын эндэгдэлд эрт болон хожуу нярайн эндэгдлийн эзлэх хувь нэмэгдэж байна. Иймд ураг, нярайн тусламж үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи нэвтрүүлэх, ингэснээр эх, нярайн эрүүл мэндийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

**Зураг 2.1 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд), аймгаар, 2009**



Зорилт 8

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусlamж үйлчилгээг зохих насны хүн бүрт хүргэж, 1990-2015 онд эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулах

Хүснэгт 2.2 Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2004	2005	2006	2007	2008	2009	2015
Улсын дундаж	199.0	158.5	98.6	93.0	69.7	89.6	49.0	81.4	50.0
УБ хот	126	171.1	79.8	73.3	71.8	73.7	55.2	78.9	-
Аймгийн дундаж	230	153.4	109.6	105.7	68.2	102.0	44.3	83.5	-

Монгол улс нь эхийн эндэгдлийн түвшингээр бүсийн орнууд болон хөгжилтэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр оронд тооцогддог.

НҮБ-ын Хүн амын сан болон Монгол улсын засгийн газраас Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөрийг 2002-2006 онд амжилттай хэрэгжүүлж дууссан, мөн 2007-2011 үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн үр дүнд эхийн эндэгдлийн түвшин 2003-2008 онд тогтвортой буурч, бага түвшинд хэвээр хадгалагдаж ирсэн.

Гэсэн хэдий ч 2009 онд 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 81.4 болж өмнөх оноос 1.5 дахин нэмэгдсэн байна. Энэ нь эхийн эндэгдлийн түвшин тогтвортой буурахгүй байгааг харуулж байна.

Зорилт 9

2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний тархалтыг зогсоож, БЗДХ-ыг бууруулж эхлэх

Монгол улсын нийт хүн амын дундах Хүний дархлал хомсдолын вирусийн халдварт (ХДХВ), дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ын тархалтын түвшин 1.0 хувиас бага байгаа нь зүүн ази, Номхон далайн баруун бүсийн зарим орнуудтай харьцуулбал ХДХВ, ДОХ-ын тархалт багатай 5 улс орны тоонд багтдаг хэдий ч ХДХВ-ын халдварт бүртгэгдсэн тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна.

1992 онд Монгол улсад анхны ХДХВ/ДОХ-ын тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2009 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 62 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 13 тохиолдол нь 2009 онд бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 62 тохиолдлын 10 нь нас барсан байна. ХДХВ/ДОХ-ын нийт 62 тохиолдлын 90 хувь нь буюу 57 тохиолдол нь 2005-2009 онд бүртгэгдсэн байна.

ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 49 (80%) нь эрэгтэйчүүд, 12 нь (20%) нь эмэгтэйчүүд байна. ХДХВ-ийн халдвартай гэж бүртгэгдсэн тохиолдлууд 100% бэлгийн замаар халдварт авсан байна.

ХДХВ-ийн халдвартын 33 (54.1%) тохиолдол идэвхитэй тандалтаар, 18 (29.5%) тохиолдол сайн дурын шинжилгээгээр, 10 (16.4%) тохиолдол нь өвчний улмаас эмнэлэгт хандсан болон хэвтэн эмчлүүлж буй хүмүүсээс илэрсэн байна.

ХДХВ/ДОХ-той хүмүүсийн гэр бүлд амьдарч байгаа 25 хүүхдийн 3 хүүхэд бүтэн өнчин хүүхэд байна.

Зорилт 10

2015 онд гэхэд сүрьеэ өвчний тархалтыг зогсоож, бууруулж эхлэх

Монгол улсад сүрьеэ өвчиний илрүүлэлт, эмчилгээний чанар сайжирч, нас баралтын түвшин буурч байгаа боловч өвчлөлийн түвшин нэмэгдэж байгаа нь тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болж байна.

Сүрьеэ өвчин нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын амьжиргааны тувшинтэй шууд хамааралтай байдаг. Манай орны хувьд 1990-ээд оноос эхэлсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үр дагаврууд болох инфляци, ажилгүйдэл, ядуурал, шилжилт хөдөлгөөн зэрэг нь уг өвчиний тархалтад нөлөөлж байна. ДЭМБ-ын судалгаагаар Номхон далайн баруун бүсэд багтдаг сүрьеэгийн өвчлөл өндөртэй 7 орны 3 дугаарт Монгол улс орж байна.

Хүснэгт 2.3 Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин (100 000 хүн амд), сонгосон онуудаар

Он	1990	2000	2004	2005	2006	2007	2008	2009	2015
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин									
Улсын дундаж	79	125	176	175	185	166	159	156	40
УБ хот	85	180	264	264	259	225	227	213	-
Аймгийн дундаж	63	99	129	123	132	123	115	113	-
Сүрьеэгийн нас баралтын түвшин									
Улсын дундаж	4.8	3.2	3.8	4.0	2.9	2.5	2.7	2.8	-
УБ хот	5.4	2.5	3.3	3.3	3.3	2.3	3.2	2.7	-
Аймгийн дундаж	3.9	2.0	4.5	4.3	2.5	2.6	2.4	2.9	-
ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь									
Улсын дундаж	-	100/80	100/83	100/79	100/82.1	100/83.8	100/85.0	100/84.2	-
УБ хот	-	100/84	100/84	100/74	100/78.4	100/80.6	100/83.2	100/80.2	-
Аймгийн дундаж	-	100/81	100/87	100/84	100/87.1	100/88.0	100/87.2	100/88.0	-

100.000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 1990 онд 79 байсан бол 2000 онд 1.5 дахин, 2004-2006 онд 2-2.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2007 оноос эхлэн өвчлөл буурч эхэлсэн ба 100.000 хүн амд сүрьеэгийн өвчлөлийн түвшин 2007 онд 166, 2008 онд 159, 2009 онд 156 ногдож байна.

2009 оны байдлаар улсын хэмжээнд сүрьеэгийн 4218 тохиолдол шинээр бүртгэгдсний 60.1 хувийг (2535) уушигны, 39.9 (1683) хувийг уушигны бус эрхтний сүрьеэ эзэлж байна. Уушгины сүрьеэгийн 71,4 хувь нь (1809) уушгины түрхэц эерэг сүрьеэ байна

Сүрьеэ өвчиний улмаас нас барсан хүмүүсийн тоо харьцангуй буурч байна. Сүрьеэ өвчиний улмаас 1992-1995 онуудад жилд дунджаар 121 хүн нас барж байсан бол 1996-1999 онуудад 113; 2000-2003 онуудад 75; 2004-2009 онуудад 80 тохиолдол болж буурчээ.

Сүрьеэгээр өвчлөгсдийн 71.4 хувь нь 16-44 насны хөдөлмөрийн насны хүмүүс байгаа бөгөөд хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд 50.9 хувь, эмэгтэйчүүд 49.1 хувийг эзэлж байна.

Дэлхийн бусад улс орнуудын адил манай улс 1990-ээд оны үеэс шууд хяналттай богино хугацааны эмчилгээний бодлого, стратегийг (ДОТС) өргөжүүлж нэвтрүүлсэнтэй холбоотойгоор сүрьеэгийн тархалт, нас баралт хяналтанд орох хандлагатай болж байна.

БҮЛЭГ 3. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

3.1 Эхийн эрүүл мэнд

- ♦ Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино гэж заажээ. Эх хүүхдэд тэтгэмж олгох, шинээр гэрлэгчид болон төрсөн хүүхдэд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхэд жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэхтэй холбогдсон харилцаа зэргийг хуулиар зохицуулж байна.
2009 онд:
- ♦ “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги 2005-2010”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 3 дахь хөтөлбөр 2007-2011”, Мянганы хөгжлийн тав дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор

Зураг 3.1 Эхийн эндэгдэл 100.000 амьд төрөлтөд /1999-2009/



“Эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний тухай” ЭМС-ын 149 тоот тушаал, мөн томуугийн А хүрээний (H1N1) вирусийн шинэ цартахал гарсантай холбоотой жирэмсэн эмэгтэй хэт эрсдэлтэй байгааг анхааран “Томуугийн халдвартын үед жирэмсэн эмэгтэйд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг чанаржуулах тухай” ЭМС-ын 370 тоот тушаалууд тус тус батлагдан гарсан байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ энэ онд хийгдэж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаа өргөжиж, төрийн болон ТББ-үүд, хувийн хэвшлийн байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтэд идэвхтэй оролцсоныг цохон тэмдэглэсэн байна. Нийт хүн амд болон зорилтот бүлгийнхэнд чиглэгдсэн НҮЭМ-ийн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлууд өргөн хүрээнд хийгджээ. Мөн эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг сайжруулах чиглэлээр сургалт, семинаруудыг тогтмол зохион байгуулж, эх барихын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр амаржих газруудыг хангаж, тусламж үйлчилгээний чанарт эерэгээр нөлөөлсөн байна.

НҮЭМ-ийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамжийн үндэсний стратеги 2009 онд батлагдаж НҮЭМ-ийн эм, хэрэгслийн хангамжийг тогтвортжуулах асуудлаар томоохон ахиц гарав. 2009 онд Монгол улс анх удаа улсын төсөвт НҮЭМ-ийн эм, хэрэгслийн зардлын санхүүжилт батлагдсан нь НҮЭМ-ийн эм хэрэгслийн тогтвортой байдлыг хангахад чухал арга хэмжээ болжээ.

3.1.1. Жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

Жирэмсний хяналт нь жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэлд хүргэж болзошгүй эрсдэлт хүчин зүйлийг цаг алдалгүй тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжийг бүрдүүлж өгдөг. Жирэмсний хүндрэлгүй эмэгтэйчүүд жирэмсний хугацаандаа 6-аас доошгүй удаа эмчийн хяналтанд үзүүлсэн байх журмыг баримталдаг билээ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шат болох сум, өрхийн эмнэлгийн үйлчилгээнд жирэмснийг эрт илрүүлж, хянах, эрсдэлтэй болон жирэмсний хүндрэлтэй эхчүүдийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх, хэвийн төрөлтийг их эмчийн хяналтан дор удирдах, төрсний дараах эх, нярайг хянах, гэр бүл төлөвлөлтийн асуудал, эхийн амрах байрны хэвийн үйл ажиллагааг хангах асуудлууд нэн тэргүүнд тавигдсаар байна. Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэл, эх нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулахад жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ чухал юм. Жирэмсэн эмэгтэйд үзүүлэх


төрөхийн өмнөх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг болох жирэмсэн эхчүүдийг амин дэм болон бичил элементээр хангах үйл ажлын хүрээнд Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах тухай ЭМС-ын 2009 оны 321 тоот тушаал батлагдан гарсан.

Жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний эрт үеийн болон байнгын хяналтад орох нь хавсарсан өвчлөлийг оношлох, эмчлэх, улмаар жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

2009 оны байдлаар нийт хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 83.2 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа хяналтад хамрагджээ, Хот, хөдөөгөөр авч үзвэл хотод 80.3 хувь нь, хөдөө орон нутагт тухайн эмэгтэйчүүдийн 85.5 хувь нь жирэмсний эрт үеийн хяналтад хамрагдсан байна. Хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайд хамралтын хувь 1,2 байна.

Жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг шинжилгээнд хамруулах нь цус багадалт, жирэмсний хожуу хордлого, бөөрний эмгэг, ургийн болон бусад эмгэгийг эрт илрүүлж, холбогдох хүндрэлээс сэргийлэх боломж бүрддэг. Эрүүл мэндийн сайдын 2004 оны 197 тоот тушаалын дагуу “ Жирэмсэн эмэгтэйчүүдэд ХДХВ/ДОХ-ын үзлэг, шинжилгээ хийх журам”-ын дагуу жирэмсэн эмэгтэйгээс зөвшөөрөл авсаны үндсэн дээр шинжилгээ хийхийг заасан. Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 91.5 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдснаас 7.9 хувь нь цус багадалттай байна. Тухайн эмэгтэйчүүдийн 90.2 хувь тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.9 пунктээр нэмэгдсэн байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд хамрагдснаас 1.9 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Баянхонгор 5.5, Орхон 3.3, Дорноговь 3.4, Сэлэнгэ 2.4, Улаанбаатар 2.2 хувьтай байна. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 63.9 хувь нь рентген шинжилгээнд хамрагдаж идэвхитэй сүрьеэгийн 90 тохиолдол илэрсний 75.5 хувь нь Улаанбаатар хотод байна.

Зураг 3.2 Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, 2009 он




Эхийн амрах байр нь алслагдсан хөдөөгийн багийн болон нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд төрөх шаардлагатай эхчүүдийг сум, аймгийн эмнэлэгт төрүүлэх, гэрийн төрөлтөөс сэргийлэх, эхчүүдийг мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамруулах, боломжийг бүрдүүлдэг манай улсын өвөрмөц тусламж үйлчилгээний хэлбэр юм.

Жирэмсэн эмэгтэйг төрөхөөс өмнө эмчийн зөвлөсөн хугацаанд, төрсөн эхийг төрсний дараа амаржих газраас гарснаас хойш 7 хүртэлх хоногоор амраах үйл ажиллагааг жигдриүүлэхэд эхийн амрах байрны гол зорилго оршино.

2009 онд эхчүүдийн амрах байр улсын хэмжээнд 336 ажиллаж байгаагаас 310 нь сумын төвд, 22 нь аймгийн төвд, Улаанбаатар хотын эмнэлэгт 3, бусад газар 1 ажилласан байна.

Эдгээр байрны 105 нь зориулалтын байранд байгаа ба 231 нь эмнэлэг дотор байрлаж байна. Эхчүүдийн амрах байрны дундаж ор хоног 7.9 байна. 2009 онд 14 амрах байр шинээр баригдаж, 97 буюу 28,8 хувьд нь засвар үйлчилгээ, тохижилт хийгдсэн байна.

Зураг 3.3 Жирэмсэн байхдаа 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь 2009 он



Нийт амарвал зохих эхчүүдийн 71.0 хувь нь амрах байранд амарсан байна. 2009 оны байдлаар нийт төрсөн эхчүүдийн 84.1 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад байж төрсөн байна.

Харин хяналтад ороогүй төрсөн эмэгтэйчүүд 0.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны үеэс нэмэгдсэн байна. Дорноговь, Дорнод, Улаанбаатар хотод энэ үзүүлэлт нэмэгдсэн байна.

3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ

Эхчүүдийг аль болох эмнэлэгт төрүүлэх, эмнэлгүүдийг сайтар бэлтгэгдсэн эх баригчид бусад мэргэжилтнээр хангах, нийт жирэмсэн эхчүүдийг жирэмсний хяналтад авах нь чухал юм. Анхан төрөгчид, мөн ихэр жирэмсэн, 35-аас дээш насны төрөгчид, жирэмсний хяналтад хэт хожуу хамрагдагсад, өмнөх төрөлтүүдийн үед хүндрэл гарч байсан болон хүүхэд нь эндэж байсан эхчүүд, тэжээлийн дутагдалтай буюу архаг хуучтай жирэмсэн эхчүүдийг орон нутгийн бэлтгэгдсэн эмнэлэгт төрүүлэх шаардлагатай. Нийт хөдөөгийн эмэгтэйчүүдийн 40 орчим хувь нь аймгийн төв, Улаанбаатарт ирж төрдөг ба бус нутгаар авч үзвэл баруун бүсэд sumaас аймагт, аймгийн төвөөс Улаанбаатарт ирж төрөх нь хамгийн бага байна гэсэн дүгнэлт 2008 оны Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаагаар гарчээ. Мөн хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 99 хувь нь төрөх үедээ эмнэлгийн ажилтны тусlamж авч, эмэгтэйчүүдийн их эмчийн тусlamж авч төрсөн эмэгтэйчүүдийн хувь хотод /53 хувь/ хөдөөгөөс өндөр, харин эх баригч бага эмчийн тусlamж авч төрсөн эмэгтэйчүүдийн хувь хөдөөд /37 хувь/ хотоос /21 хувь/ өндөр байна.

Улсын хэмжээнд 68544 эх төрсөн нь 2008 онтой харьцуулахад төрөлт 5457 тохиолдлоор нэмэгдсэн байна. Төрөлт өнгөрсөн оны мөн үеэс улсын хэмжээнд бүх аймгуудад болон Улаанбаатар хотод нэмэгджээ. 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 25.3 байгаа ба энэ үзүүлэлт Дархан-Уул 29.09, Дорнод 26.18, Орхон 30.15, Увс 30.00, Улаанбаатар хотод 27.73 өндөр байна. Нийт төрөлтийн 42.3 хувь нь Улаанбаатар хотод, 41.3 хувь нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 13.2 хувь нь сум болон сум дундын эмнэлэгт, 2.9 хувь нь хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт, 0.4 хувь нь гэртээ төрсөн байна. Нийт төрсөн эхчүүдийн 39.9 хувь нь анхны төрөлт

байгаа ба нийт төрөлтийн 6.7 хувийг их эмч, 83.3 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн их эмч, 9.6 хувийг эх баригч бага эмч удирдан явуулсан байна. 20-оос доош насны төрөлтийн эзлэх хувь 6.1 байгаа ба 35-иас дээш насны төрөлтийн эзлэх хувь 12.0 байна. Төрөлт нэмэгдэхийн хэрээр гэртээ төрсөн эхчүүдийн хувь хэмжээ нэмэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 0.1 пункттээр буюу 59 тохиолдлоор нэмэгджээ. Нийт гэрийн төрөлтийн 47.0 хувь нь эмнэлгийн тусlamжгүй төрсөн нь энэ үзүүлэлт хотод өнгөрсөн оныхоос 9.4 пункттээр буурсан нь өмнөх онуудтай харьцуулахад эмнэлгийн тусlamжгүй төрөлтийн хувь буурсаар байгаа билээ.

Хүснэгт 3.1 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2009 он

Нийт төрөлт	Үүнээс гэртээ	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт	Сум, сум дундын эмнэлэгт	Бага эмчийн салбарт	УБ хотын амаржих газар болон ЭНЭШТ-д	Хувийн эмнэлэгт
Архангай	2045	1	1181	0	862	1	0
Баян-Өлгий	2558	0	1739	0	819	0	0
Баянхонгор	2047	8	1571	0	468	0	0
Булган	1060	5	697	0	358	0	0
Говь-Алтай	1374	9	1018	0	345	2	0
Говьсүмбэр	361	1	359	0	1	0	0
Дархан-Уул	2592	16	2461	0	115	0	0
Дорноговь	1337	9	1028	225	75	0	0
Дорнод	1927	12	1794	0	121	0	0
Дундговь	1085	2	777	0	306	0	0
Завхан	1878	1	875	313	689	0	0
Орхон	2489	17	2462	0	10	0	0
Өвөрхангай	2942	14	1693	336	860	9	0
Өмнөговь	1280	5	1043	0	232	0	0
Сүхбаатар	1192	2	1051	0	139	0	0
Сэлэнгэ	1848	3	891	620	334	0	0
Төв	934	1	501	0	432	0	0
Увс	2379	25	1493	0	860	1	0
Ховд	2227	4	1428	325	470	0	0
Хөвсгөл	3149	3	1861	0	1285	0	0
Хэнтий	1560	3	1090	185	282	0	0
Аймгийн дүн	38264	141	27013	2004	9063	13	0
Улаанбаатар	30280	127	1314	0	4	0	28685
Улсын дүн	68544	268	28327	2004	9067	13	28685
							180

3.1.3 Төрсний дараах үеийн тусlamж, үйлчилгээ

Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдийг 2011 он гэхэд жирэмсний эрт үеийн хяналт, эхийн амрах байрны үйлчилгээ, эмнэлэгт төрөх хувь, төрсний дараах идэвхитэй хяналт гэх зэрэг үйлчилгээг тодорхой түвшинд хүргэхээр заасан билээ. 2008 оны Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаанд хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 46 хувь нь жирэмсэн үедээ ямар нэг хавсарсан өвчинөөр өвдөж байсан гэсэн нь 1998 оныхоос 13 пункттээр, 2003 оныхоос 0,4 пункттээр өсчээ. 2009 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн нийт 43623 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 634.4 байна.

Нийт тохиолдлын:

- жирэмсэн үеийн хүндрэл- 35.6 хувь,
- төрөх үеийн хүндрэл- 45.9 хувь,
- төрсний дараах үеийн хүндрэл- 1.5 хувь,
- жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчиний хүндрэл- 16.8 хувийг тус тус эзэлж байна.

Жирэмсэн эмэгтэйчүүд БЗДХалдвартай, төрөлх тэмбүүтэй хүүхэд төрөх тохиолдол ихэсч байгаа нь жирэмсний хяналт, тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулахыг анхааруулж байгаа юм. Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал болон манас таталт 59.3 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчиний анхдагч болон хоёрдогч суралт 27.0 хувь, төрсний дараах үеийн хүндрэлээс хожуу үеийн цус алдалт 53.8 хувьтай тэргүүлж байна.

Нийт төрсөн эхчүүдийн 29,1 хувь нь жирэмсэн байх үедээ ямар нэгэн хавсарсан өвчнөөр өвдсөн байна. Үүнээс:

- шээс бэлгийн тогтолцооны өвчин- 39,2 хувь
- цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан эмгэг-17,2 хувь
- зүрх-судасны тогтолцооны өвчин- 11,4 хувь эзэлж эхний 3 шалтгаанд тэргүүлж байна.

Төрсний дараах анхаарал халамжийг сайжруулан идэвхитэй үзлэгийг эх нярайд үзүүлэх, төрсний дараа 42 хоногтойдоо эмчийн хяналтад орох, төрсөн эхчүүдэд хүүхдээ асрах, хөхөөр хооллох, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр зөвлөгөө өгөх нь тусlamж үйлчилгээний нэг гол асуудал билээ.

2008 оны Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаагаар төрсний дараах 42 хоногийн дотор зөвлөгөө авсан эхчүүдийн хувь 2003 оны судалгааны үеэс өссөн байна. Үүний дотор хөхөөр хооллолт, нярайн асаргааны талаарх зөвлөгөө 2 пункт, гэр бүл төлөвлөлтийн талаарх зөвлөгөө 6 пункт, БЗДХ-ын талаарх зөвлөгөө 11 пунктээр нэмэгджээ гэсэн дүгнэлт гарсан байна. 2009 оны эрүүл мэндийн статистикийн бүртгэлээр хяналтад байж төрсөн эхчүүдээс төрсний дараа 42 хоногтойдоо эмчийн идэвхитэй хяналтад хамрагдсан хувь 84.2 байгаа нь өнгөрсөн оны байдалтай харьцуулахад 6.0 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой үзүүлэлт юм.

3.1.4 Хүүхдийн эрүүл мэнд ба хөхөөр хооллолт

Сүүлийн жилүүдэд нялхас, хүүхдийн эндэгдэл, тураалын түвшин буурч, хүүхдийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд нилээд сайжирсан нь бага насын хүүхдийн өвчнийг цогцоор оношилж, эмчлэх олон улсын стнадарт нэвтрүүлж, хүүхдийг эхийн сүүгээр бойжуулах бодлогыг эрчимжүүлэн, дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн зэрэг олон хүчин зүйлийн үр дүн билээ.

Хүснэгт 3.2 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2009 он

Бүсээр	Төрсөн хүүхэд				Нийт төрөлтэд	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа /100-д/	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлтийн түвшин/1000 төрөлтд/
Баруун бүс	10387	5280	5107	103.4	4.4	12.3
Төвийн бүс	9456	4825	4631	104.2	3.0	5.5
Хангай, говийн бүс	13787	7070	6717	105.3	4.3	5.7
Зүүн бүс	4695	2410	2285	105.5	3.6	7.4
Аймгийн дүн	38325	19585	18740	104.5	3.9	7.6
Улаанбаатар	30437	15656	14781	105.9	4.5	6.2
Улсын дүн	68762	35241	33521	105.1	4.2	7.0

Улсын хэмжээнд 68762 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 5500 хүүхдээр буюу 8.7 хувиар нэмэгдсэн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.2 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдээс 1342 нь хоёр ихэр, 27 нь гурван ихэр байна. Амьгүй төрөлт 1000 төрөлтөд 7,01 байгаа ба нийт 486 тохиолдлоос баруун бүсэд 26,5 хувь байгаа нь бусад бүс нутгаас өндөр байна. Амьгүй төрөлтөд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь ихэнхи бүс нутгуудад өндөр байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 105.1 байна. 2009 онд 1 хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын 99.1 хувь, 5 хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын 94.9 хувь байна.

Төрсөн хүүхдийн тавны дөрвөөс /81 хувь/ илүү нь төрсний дараах нэг цагийн дотор хөхөө амласан ба, 6 сар хүртэлх насны хүүхдүүдийн 82 хувь нь дан хөхөөр хооллож байсан нь судалгаагаар гарчээ. Энэ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжтэй нийцэж байгаа юм.


3.1.5. Эхийн эндэгдэл


Мянганы хөгжлийн зорилтын чухал үзүүлэлт болох эхийн эндэгдлийг 2015 он гэхэд 100 000 амьд төрөлтөд 50,0 болгох зорилтын хүрээнд “Эхийн эндэгдлийг бууруулах тухай” ЭМ-ийн Сайдын 2005 оны 190 тоот тушаал, “Мянганы хөгжлийн тав дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний тухай” ЭМС-ын 149 тоот тушаал амжилттай хэрэгжсээр байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд (HYEM)-ийн тусlamжийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн эмнэл зүйн удирдамжийг боловсруулж хэрэгжүүлэх, эрсдэл өндөртэй эхчүүдийг нарийн мэргэжлийн шатлалын тусlamжинд эрт илгээх, баг, сум, өрхийн эмч, эх баригч ба эмэгтэйчүүдийн эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нэн шаардлагатай эм багаж төхөөрөмжөөр хангах зэрэг олон арга хэмжээ авч байгаа нь эхийн эндэгдлийг бууруулах таатай нөхцөл бүрдүүлсээр байна.

100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин өнгөрсөн оны мөн үед 49.0 байсан бол энэ онд 81.4 болж нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд нийт 56 эх эндсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 25 тохиолдлоор нэмэгдэж, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Увс аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол голаагүй байна. 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийг сүүлийн 3 жилээр бүсээр авч үзвэл.

Зураг 3.4 Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, бүсээр , 2007-2009 он



Зураг 3.5 Эхийн эндэгдэл, эмнэлгийн тусlamж үйлчилгээний шаталаа, 2009 он

Эндсэн эхчүүдийн 33.9 хувь жирэмсний үеийн хүндрэл, 7.1 хувь нь төрөх үеийн хүндрэл, 14.3 хувь нь төрсний дараах хүндрэл, 44.6 хувь нь жирэмсэн болон төрөхөөс бусад өвчний улмаас эндсэн байна.

Энэ үзүүлэлтээс харахад өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад жирэмсэн үеийн хүндрэл 4.9 пункт, жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчний шалтгаан 12.3 пунктээр тус

тус нэмэгдсэн байна. Ялангуяа жирэмсэн үеийн хүндрэлийн шалтгаан нэмэгдэж байгаа нь жирэмсний эрт үеийн болон байнгын хяналтыг сайжруулах, хавсарсан өвчлөлийг эрт оношлох, эмчлэх шаардлага гарч байна.

Эндсэн эхчүүдийн 82.0 хувийг 20-34 насны, 18.0 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүд эзэлж байна.

3.1.6 Үр хөндөлт

Гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, ойлголт, дадал хэвшил, хэрхэн нэмэгдэж байгаа болон энэ чиглэлээр үзүүлж буй тусlamж үйлчилгээ, бодлого хөтөлбөр хүн амд хэрхэн хүрч байгааг харж болох нэгэн үзүүлэлт бол үр хөндөлтийн түвшин байдаг. Сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж, эмэгтэйчүүдийн төрөх сонирхол нэмэгдсэн ба мөн төр засгаас үзүүлж буй төрөлтийг дэмжих нийгмийн халамжийн бодлого хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байгаа нь үр хөндөлтийн түвшин буурч байгааг 2008 оны судалгаагаар харагджээ. Гэсэн хэдий ч НҮЭМ-ийн нэг тулгамдаж буй асуудал бол үр хөндөлтийн түвшин тогтвортой буурахгүй байгаагаас гадна үр хөндөлтийн тоо бодиттойгоор мэдээлэгдэхгүй байгаа явдал юм. Аюулгүй үр хөндөх үндэсний стандартад үр хөндөх эрх бүхий эмнэлгүүдэд эх барих эмэгтэйчүүдийн эмч гүйцэтгэх, үр хөндөлтийн цогц тусlamж үйлчилгээнд орчин үеийн аргуудыг нэвтрүүлснээр үр хөндөлтөөс үүдэлтэй хүндрэл болон нас барах тохиолдол буурах явдал харуулж байна.

Эрүүл мэндийн 2009 оны статистик мэдээгээр 1000 амьд төрөлтөд 183.3, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 15.3 үр хөндөлт ногдох байна. Өнгөрсөн оны мөн үеэс 1914 тохиолдоор буюу 1000 амьд төрөлтөд ногдох түвшин 14.4 нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Дархан-Уул, Орхон болон Улаанбаатар хотод нэмэгдсэн нь хот суурин газар үр хөндөлтийн үйлчилгээний хүртээмж илүүтэй байгаа нь харагдаж байна. Мөн хувийн эмнэлгээр хийгдсэн үр хөндөлт өмнөх онуудаас нэмэгдсэн байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 4.1 хувь байгаа ба өнгөрсөн жилтэй харьцуулахад 0.5 пунктээр нэмэгдсэн байна. Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 6.2 хувийг 20-иос доош насны, 70.1 хувийг 20-34 насны, 23.7 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 30.6 хувь нь төрөөгүй буюу анхны удаа үр хөндүүлсэн байна. Үр хөндөлтийн улмаас гарсан хүндрэлийг авч үзвэл цус алдалт болон умайн дайврын үрэвсэл дийлэнх хувийг эзлэж байна.

3.1.7 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСА/

Гэр бүл төлөвлөлтийн талаарх хүн амын мэдлэг, хэрэглээ жилээс жилд өсч орчин үеийн ЖСАХ-ийн хэрэгцээ нэмэгдсээр байна. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргуудад бэлгэвч (эрэгтэй, эмэгтэй), ерөндөг, норплант суулгац (дааврын), жирэмслэхээс сэргийлэх эм, үтрээний хаалт, умайн хүзүүний таглаа, эр бэлгийн эсийг хөнөөгч бодис, үрийн суваг боох (эр, эм) зэрэг аргууд багтана. 2008 оны судалгаагаар нийт эмэгтэйчүүдийн 78 хувь, гэр бүлтэй эмэгтэйчүүдийн 91 хувь нь ЖСАХ-ийг ямар нэгэн арга хэрэглэж байсан гэсэн дүгнэлт гарсан байна.

2009 оны байдлаар эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр орчин үеийн ЖСА-ын хэрэглээний хувь 53.2 болсон нь жилээс жилд өсөж байна. Нөхөн үржихүйн насы 1000 эмэгтэйн 531.6 нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг байна. Харин тэдний голчлон хэрэглэж байгаа нь ерөндөг 27.1 хувь, бэлгэвч 35.4 хувь, бэлдмэл /эм / 22.5 хувь байна. Хэрэглээний аргад өнгөрсөн оны мөн үеийнхээс бэлгэвч хэрэглэх аргын хувь 4.7 пунктээр нэмэгдсэн байна.

3.2 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөл эндэгдэл

2004 онд батлагдсан Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол улсын мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-т 2015 он гэхэд нялхсын эндэгдлийг 1990 оны түвшингээс 4 дахин бууруулна хэмээн тодорхойлсон байдаг. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаарх хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илтгэх үзүүлэлтүүд болох нялхсын болон 5 хүртэлх насы хүүхдийн эндэгдэл нь сүүлийн жилүүдэд тогтвортой буурах хандлагатай байна.

Манай улсын хувьд өнгөрсөн 15 жилийн хугацаанд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 35.3-19.4 болсон бөгөөд энэхүү бууралтыг эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай холбон тайлбарлаж болон юм. 2008 оны судалгаагаар нярайн болон нялхсын эндэгдэл хөдөөд хотоос хотоос харьцангуй өндөр байхад өсрэгээр хүүхдийн эндэгдэл хотод хөдөөгөөс өндөр байна.

Нялхас болон 5 хүртэлх насы хүүхдийн эндэгдэл бүс нутгаар ялгаатай, Баруун бүс нутагт хамгийн өндөр, өмнөд бүс нутагт бага байна гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Нялхсын эндэгдэл буурахын хирээр нийт эндэгдлийн дотор нярайн эндэгдлийн эзлэх хувь нэмэгдсээр байна. Нярайн эндэгдэл нь жирэмсэн эхийн эрүүл мэнд, төрөх үеийн хүндрэлтэй ихээхэн холбоотой байдаг.

2009 оны байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насы хүүхдийн эндэгдлийн түвшин 23.6 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.2, нялхсын эндэгдлийн түвшин 20.2 хүрч 1000 амьд төрөлт тутамд 0.6 эндэгдлээр тус тус нэмэгджээ. Ялангуяа Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баянхонгор аймгуудад нялхас болон 5 хүртэлх насы хүүхдийн эндэгдэл улс, аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна. Нийт нялхсын эндэгдлийн дотор 62.7 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна.

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд перинаталь үед үүссэн зарим эмгэг 52.4 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 19.2 хувь, төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг 11.2 хувь байгаа нь эхний тэргүүлэх 3 шалтгаан болж байна. Нялхсын эндэгдэлд амьсгалын тогтолцооны шалтгаан сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 1.9 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 3.3 Нялхас болон 1-4 насны хүүхдийн нас баралтын шалтгаан, байршилаар, 2009 он

	1 хүртэлх насны		1-4 насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	11.1	24.5	25.0	38.5
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	2.2	5.8	6.5	7.4
Перинаталь үед үүсэх оёг	63.3	45.3	0.0	0.0
Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг	14.4	9.2	8.7	2.7
Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	4.9	8.6	41.3	33.1



Тэргүүлэх шалтгаан
Хоёрдугаар шалтгаан
Гуравдугаар шалтгаан

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд хот болон хөдөөд перинаталь үед үүссэн зарим эмгэгийн өвчлөлийн нас баралт тэргүүлэх шалтгаан болж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирусийн халдварт гарсантай холбоотой нялхсын эндэгдэлд амьсгалын тогтолцооны өвчиний шалтгаант нас баралт 4.4 пункт, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6.8 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.4 Нялхас болон 1-4 насны хүүхдийн өвчлөл шалтгаан, байршилаар, 2009 он

	0-1 хүртэлх насны		1-4 насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	16.1	42.8	15.7	39.6
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	5.1	9.0	3.9	8.8
Перинаталь үед үүсэх оёг	3.3	1.0	0.0	0.0
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	1.2	0.6	3.8	1.1
Халдварт ба шимэгчт зарим өвчин	0.5	0.3	2.5	1.8
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	2.4	2.7	5.0	3.3
Чих ба хөхлөг сэргээгийн өвчин	0.7	3.4	0.6	1.9




Тэргүүлэх шалтгаан
Хоёрдугаар шалтгаан
Гуравдугаар шалтгаан

Нялхас болон 1-4 хүртэлх насны хүүхдийн өвчлөлд хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж жилээс жилд нэмэгдсээр байна. Ялангуяа бага насны хүүхдийн дунд цочмог залгиуртас 39.8 хувь, томуу, томуу төст өвчлөл 46.8 хувиар нэмэгдсэн нь Томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирусийн халдварт гарсантай холбоотой юм.

**Хүснэгт 3.5 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, насны бүлгээр,
/10000 хүн амд/, 2009 он**

	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	3629.9	1093.6	878.0	664.3
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	832.4	679.7	681.1	612.4
Халдварт ба шимэгчт зарим өвчин	282.9	211.0	120.8	153.8
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	384.3	255.2	304.8	359.3
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	132.6	131.5	247.3	449.0
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	546.1	291.3	320.3	390.2



Тэргүүлэх шалтгаан
Хоёрдугаар шалтгаан
Гуравдугаар шалтгаан

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны болон арьс ба арьсан доорх эслэгийн өвчний эмгэгүүд дийлэнх тохиолдлыг эзэлж байна. Жилээс жилд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг өсвөр үеийнхний дунд нэмэгдэж, ялангуяа 10-14 насны хүүхдийн дунд 17.2 пунктээр нэмэгдсэн байна. Өсвөр насны хүүхдийн эндэгдэл өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан тэргүүлж байна.

БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улс нь эмнэлгийн тусlamж үйлчилгээний 3 шатлалт тогтолцоотой бөгөөд эмнэлгийн тусlamж үйлчилгээнд баримтлах зарчим нь үйлчилгээг хүн бүрт жигд, хүртээмжтэй чанартай үзүүлэх явдал юм.

- Анхдагч шатлалын тусlamж үйлчилгээг УБ хотод өрхийн эмнэлгүүд, аймагт сумын болон сум дундын эмнэлэг
- Хоёрдогч шатлалын тусlamж үйлчилгээг УБ хотод дүүргийн нэгдсэн эмнэлэг, аймагт аймгийн болон хөдөөгийн нэгдсэн эмнэлэг
- Гуравдагч шатлалын тусlamж үйлчилгээг УБ хотод клиникийн эмнэлгүүд болон төрөлжсөн мэргэжлийн төвүүд тус тус үзүүлж байна.

2009 оны байдлаар клиникийн эмнэлэг болон төрөлжсөн мэргэжлийн төв - 16, бүсийн оношилгоо эмчилгээний төв - 4, аймгийн нэгдсэн эмнэлэг -17, дүүргийн нэгдсэн эмнэлэг -12, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг - 6, сум дундын эмнэлэг - 35, сумын эмнэлэг - 277, өрхийн эмнэлэг - 226, хувийн ортоj эмнэлэг – 160, үүдэн эмнэлэг-922 ажиллаж эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 4.1 Эрүүл мэндийн байгууллагууд тусlamж үйлчилгээний шатлалаар

Эрүүл мэндийн байгууллагууд	Toо
Анхдагч шатлалын эмнэлгүүд	556
Өрхийн эмнэлэг	226
Сум/ тосгоны эмнэлэг	277/18
Сум дундын эмнэлэг	35
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	35
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг	17
Гуравдагч шатлалын эмнэлгүүд	20
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	4
Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвүүд	16
Амаржих газрууд	3
Бусад эмнэлгүүд /Хилийн цэрэг, төмөр зам, хориходын эмнэлгүүд/	49
Ортоj хувийн эмнэлэг	160
Үүдэн хувийн эмнэлэг	922
Аршаан сувилал, сувилал	13
Эм ханганд нийлүүлэх байгууллага	144
Эмийн үйлдвэр	57
Хувийн эмийн сан	636
Бусад	60
Бүгд	2655

4.1 Өрхийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээ

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эмнэлгүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ.

2009 оны байдлаар 226 өрхийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 112.3 мянган хүн амд 124 өрхийн эмнэлэг, 21 аймгийн төвийн 609.9 мянган хүн амд 102 өрхийн эмнэлэг анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлж байна.


Хүснэгт 4.1.1 Өрхийн эмнэлгүүдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2009 оны байдлаар

Үзүүлэлт	Өрхийн эмнэлэг		Нийт дүн
	УБ хот	Аймаг	
Эмнэлгийн тоо	124	102	226
Их эмчийн тоо	503	303	806
Сувилагчийн тоо	436	346	809
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	4 108 498	2 228 091	6 336 589
Амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	40.3	36	38.8
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	3.7	3.6	3.7
Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо	8167.2	7353.4	7760
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	82.8	80.6	81.7

226 өрхийн эмнэлэгт их эмч - 806, сувилагч -809 болон нийт 2115 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

2009 онд өрхийн эмнэлгийн түвшинд жилд дунджаар 6.3 сая үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 3.7 удаа өрхийн эмнэлэгт хандаж эмнэлгийн анхан шатны болон НЭМ-ийн тусlamж үйлчилгээг авсан байна. Амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь УБ хотын өрхийн эмнэлгийн түвшинд 40 хувьтай, харин аймгийн өрхийн эмнэлгийн түвшинд 36 хувьтай байна.

Зураг 4.1.1 Өрхийн эмнэлгүүдэд хийгдсэн амбулаторийн үзлэгийн тоо /саяаар/



УБ хотын өрхийн эмнэлгийн түвшинд 2005 онд 3.0 сая үзлэг хийгдэж байсан бол 2007 онд 3.9 сая, 2009 онд 4.1 болж нэмэгдсэн байна. Жилд нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо УБ хотод 8167.2 байгаа нь аймгийн түвшинд ажиллаж байгаа өрхийн нэг эмчид ногдох үзлэгээс 815 үзлэгээр их байна. УБ хотын түвшинд өрхийн эмнэлгүүдийн ачаалал нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд УБ хотын хүн амын тоо, төрөлтийн тоо, хөдөөнөөс УБ хотод шилжин ирж суурьшигчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болно.

4.2 Сумын болон сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2001 онд батлагдсан “Сумын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны улсын стандарт”-аар сумын эмнэлгүүд нь үйлчлэх хүрээний хүн амын тооноос хамааран 3 зэрэглэлд хуваагддаг. I зэрэглэлийн сумын эмнэлгийн үйлчлэх хүрээний хүн ам нь 4500 ба түүнээс дээш, ажиллах эмчийн доод хязгаарыг - 7, II зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд 3001-4500 хүртэл хүн ам, ажиллах эмчийн доод хязгаарыг - 3, III зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд 3000 хүртэл хүн ам, 1 эмч байхаар стандартад заасан байдал.

Хүснэгт 4.2.1 Сумын болон сум дундын эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал

Зэрэглэл	Эмнэлгийн тоо	Эмчийн тоо (дундаж)	Стандартын доод хэмжээ	Стандартын түвшинд тоо Хувь		Стандартаас доогуур Тоо Хувь	
				тоо	Хувь	тоо	Хувь
I зэрэглэл	33	3.7	7	2	6.5	31	93.9
II зэрэглэл	75	2.1	3	21	28.0	54	72.0
III зэрэглэл	180	1.6	1	173	96.1	7	3.9
Дундаж	-	-	-	193	67.7	92	32.3
Сум дундын эмнэлэг	35	4	8	2	5.7	33	94.3

Дээрх хүснэгтээс харахад I зэрэглэлийн эмнэлгийн 6.5 хувь, II зэрэглэлийн сумын эмнэлгийн 28.0 хувь, III зэрэглэлийн сумын эмнэлгийн 96.1 хувь нь стандартад заасан эмчээр хангагдаж чадаагүй байна.

III зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд стандарттаар доод тал нь 1 их эмч ажиллах ёстой бөгөөд 180 эмнэлгээс 4 эмнэлэг их эмчгүй, 97 (53.8 хувь) эмнэлэг 1 их эмчтэй, 79 (43.8 хувь) эмнэлэг 2 ба түүнээс олон их эмчтэй ажиллаж байна.

Зураг 4.2.1 Сум, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн дундаж тоо, 2009



I зэрэглэлийн сумын эмнэлэгт стандартаар доод тал нь 7 эмч ажиллах ёстой бөгөөд эмчийн дундаж тоо стандартад заасан хэмжээнээс 1.5- 2 дахин бага байгаа бөгөөд эмчийн дундаж тоо 3.7 байна.

Сум дундын эмнэлгээс 2 эмнэлэг нь стандартад заасны дагуу 8 их эмчтэй ажиллаж, үлдсэн 33 эмнэлгийн хувьд стандартадаас доогуур буюу дундажаар 4 их эмч ажиллаж байна. Өөрөөр хэлбэл эмчийн хангамж сум дундын эмнэлгүүдийн 94 хувьд стандартын түвшинд хүрэхгүй байна. Энэ үзүүлэлт нь сум дундын эмнэлгүүдийг нарийн мэргэжлийн эмчээр хангах шаардлага хэрэгцээ байгааг харуулж байна.


Хүснэгт 4.2.2. Сум, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2007 он		2009 он			Нийт дүн
	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Нийт дүн	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	
Эмнэлгийн орны тоо	3172	932	4104	3038	624	3662
Их эмчийн тоо	528	144	672	562	149	711
Сувилагчийн тоо	1411	239	1650	1373	246	2992
Дундаж ор хоног	7.7	7.9	7.9	7.8	6.4	7.1
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	116 959	23 938	140 897	114 836	25110	139 946
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	2 320 840	418 063	2 738 903	2 246 335	362 549	2 608 884
Амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	45.7	42.2	43.9	39.8	40.8	39.9
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	3.1	3.2	3.1	3	2.8	3
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	88.3	85.6	87.9	87.4	89.4	87.6
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	193.2	49.95	158.6	136.5	175.7	143.6
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	32.8	22	25.7	42.2	29.9	39.9

2009 оны байдлаар эмнэлгийн нийт орны 20.6 хувь нь сумын болон сум дундын эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2007 онтой харьцуулбал 442 ороор буюу 10.7 хувиар буурсан байна.

Сумын болон сум дундын эмнэлэгт жилд 140.0 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна. 2009 онд сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2007 онтой харьцуулахад 5 хувиар нэмэгдэж, харин сумын эмнэлэгт 2 хувиар буурсан байна.

Зураг 4.2.2 Сум, сум дундын эмнэлгийн ачаалал



Дундаж ор хоног 2007 онд 7.9 хоног байсан бол 2009 онд 7.1 болж буурсан байна.

Сумын болон сум дундын эмнэлэгт нэг иргэний үзүүлсэн дундажтоо 2007 онд 3.2 байсан бол 2009 онд 3.0 болж буурсан байна.

2009 онд сумын болон сум дундын эмнэлгийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 87.6 хувь байна.

2009 онд нийт эндсэн эхийн 23.2 хувь (13 тохиолдол) нь сумын болон сум дундын эмнэлэгт эндсэн байна. Сум дундын эмнэлгийн түвшинд 2007 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 49.9 байсан бол 2009 онд 3 дахин нэмэгдсэн байна.

2009 онд 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин сумын эмнэлгийн түвшинд 42.2, сум дундын эмнэлгийн түвшинд 29.9 болж нэмэгдсэн байна.

4.3 Хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ

2009 оны байдлаар 17 аймгийн нэгдсэн эмнэлэгт 863 их эмч, 1545 сувилагч, 2116 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 4506 эмч, эмнэлгийн мэргэжилтэн; 9 дҮҮргийн нэгдсэн эмнэлэгт 711 их эмч, 727 сувилагч, 1035 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 2531 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

2001 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны улсын стандарт MNS 5095:2001 батлагдсан бөгөөд тус стандартыг дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд мөн адил мөрдөж байна.


Уг стандартад аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллах эмчийн тоог аймгийн нийт хүн амын тоог харгалзан ялгавартай тогтоосон. 2009 оны байдлаар аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн 40 орчим хувь буюу 6 эмнэлэг стандартын шаардлагыг хараахан хангаагүй байна.

Хүснэгт 4.3.1 Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал

Аймгийн нийт хүн амын тоо	Эмчийн тоо (дундаж)	Стандартын доод хэмжээ	Стандартын түвшинд		Стандартаас доогуур	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
65500 хүртэл	41	37.5	5	71.4	2	28.6
65501-90500 хүртэл	57.3	50	4	66.6	2	33.3
90501-ээс дээш	58	58.5	2	50	2	50
Дундаж	-	-	11	62.60%	6	37,4%

Дээрх хүснэгтээс харахад 65 500 болон 65501-90501 хүртэл хүн амтай аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмчийн дундаж тоо стандартад заасан хэмжээнээс өндөр, 95501-ээс дээш хүн амтай аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмч дундаж тоо стандартад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа нь аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн орон тооны доод хязгаарыг шинэчлэн тогтоох шаардлагатай байгааг харуулж байна.


Зураг 4.3.1 Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал



Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 18 хувь нь ногдох байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд орны тоог бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. 2009 онд байдлаар аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн орыг 3209 хүртэл бууруулсан нь 2007 онтой харьцуулахад 154 ор буюу 5 хувиар буурсан.

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд нийт орны 8 нь хувь ногдох байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд орны тоог бууруулах эсвэл нэмэгдүүлэх бодлого баримтлаагүй хэдий ч дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2007 онд 58 мянга байсан бол 2009 онд 65 мянга болж, 7 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 4.3.2 Хоёрдогч, гуравдагч шатлалын эмнэлгүүдийн ачаалал



Хүснэгт 4.3.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2007 он		2009 он		Сүүлийн 3 жилийн дундаж	
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
Эмнэлгийн орны тоо	3363	1328	3209	1353	3307.7	1344.7
Их эмчийн тоо	838	697	863	711	877.3	709.3
Сувилагчийн тоо	1525	661	1545	727	1529.7	694
Дундаж ор хоног	8.5	8.2	8.1	8	8.3	8.1
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	118 098	58 801	122 352	65 509	121 803	62 606
Хоног болоогүй нас баралтын хувь	30.2		30.5	29.3	30.8	28.9
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1 354 233	1 768 400	1 535 327	1 860 310	1 508 149	1 836 642
Амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	44.7	46.3	43.3	44.5	43.8	46.1
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	55.1	-	75.9	-	59.2	-
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	21.2	-	17.2	-	18.2	-
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	34.6	-	31.2	-	30.2	-

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дундаж ор хоног 2007 онд 8.5 байсан бол 2009 онд 8.1 болж буурсан байна.

2007-2009 онд эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь аймгийн болон дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд ойролцоо буюу 30 хувьтай байна.

Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2007 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 1.3 сая, дүүргийн эмнэлгийн түвшинд 1.7 сая байсан бол 2009 онд 1.5 сая ба 1.8 сая болж тус тус нэмэгдсэн байна. Гэсэн хэдий ч амбулаторын нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь аймгийн болон дүүргийн эмнэлгийн түвшинд буурсан ба сүүлийн 3 жилийн дундаж түвшинд байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин сүүлийн 3 жилд тогтвортой буурсан бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 18.2 байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2007-2008 онд 55.1-37.8 болж хамгийн бага түвшинд хүрч байсан боловч 2009 онд 75.9 болж нэмэгдсэн байна.

Сүүлийн 3 жилд дунджаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 30.2 хувийг хөдөөнөөс буюу сум, сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна. 2009 онд хөдөөнөөс аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж хэвтэн эмчлүүлэгчид өмнөх 2007 онтой харьцуулахад 3.4 хувиар буурсан байна.

4.4 Гуравдагч шатлалын тусlamж, үйлчилгээ

2009 оны байдлаар улсын хэмжээнд Орхон, Дорнод, Өвөрхангай, Ховд аймгийн нэгдсэн эмнэлгүүд БОЭТ-ийн статусаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2009 оны байдлаар БОЭТ-үүдэд 282 их эмч, 551 сувилагч, 739 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 1501 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Хүснэгт 4.4.1 БОЭТ-ийн эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2007	2008	2009	
Эмнэлгийн орны тоо	1108	1108	1117	1111
Дундаж ор хоног	8.7	8.5	8.3	8.5
Хоног болоогүй нас баралтын хувь	33.6	33.2	28.9	31.7
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	39 039	40 941	41 820	40 600
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	471 592	469 581	447 241	462 805
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	25.6	22.2	26.8	24.9
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	10.9	14.6	10.6	12.1
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	36	35.3	28.7	31.8

2007 онд БОЭТ-д 39.0 мянган хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2009 онд 41.8 мянган хүн болж 2800 хүнээр нэмэгдсэн байна. БОЭТ-д жилд дунджаар 12000 хүн сумын болон сум дундын эмнэлэг, бүсийн аймгуудаас ирж хэвтэн эмчлүүлж байгаа нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 28.7 хувьтай тэнцэж байна.

Нэгөөтэйгүүр аймгийн нэгдсэн эмнэлэгт жилд дунджаар доод шатлалын эмнэлгүүдээс 2300 хүн ирж хэвтэн эмчлүүлж байхад БОЭТ-д дунджаар 3200 хүн буюу 900 хүнээр их байна.

БОЭТ-ийн дундаж ор хоног 2007 онд 8.7 байсан бол 2009 8.3 болж буурсан байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2007 онд 33.6 байсан бол 2009 онд 28.9 хувь болж буурсан байна.

Сүүлийн 3 жилд улсын хэмжээнд наялхсын эндэгдэл тогтвортой бага түвшинд байгаа хандлагын дагуу БОЭТ-ийн 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох наялхсын эндэгдлийн түвшин 2007 -2009 онд 1000 амьд төрөлтөд 12.1 байгаа нь улс болон аймгийн дунджаас доогуур байна. 2009 онд Орхон, Өвөрхангай, Ховд аймгийн БОЭТ-д тус бүр 1 эх эндсэн байна.

УБ хотод эмнэлгийн гуравдагч шатлал болон төрөлжсөн мэргэжлийн тусlamж үйлчилгээг клиникийн эмнэлгүүд, төрөлжсөн мэргэжлийн төвүүд үзүүлдэг.

2009 оны байдлаар 16 гуравдагч шатлалын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн төвүүдэд 1183 их эмч, 1875 сувилагч, 2384 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 5833 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Нийт эмнэлгийн орны дөрөвний нэг буюу 25 хувь нь, мөн хэвтэн эмчлүүлэгчдийн тавны нэг буюу 20 хувь нь УБ хотын гуравдагч шатлалын эмнэлэгт ногдож байна.


Дундаж ор хоног 2007 онд 10.6 байсан бол 2009 онд 10.2 болж буурсан байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2007 онд 22.4 байсан бол 2009 онд 19.8 хувь болж буурсан бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 21.4 хувь байна.

Хүснэгт 4.4.2 УБ хотын гуравдагч шатлалын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2007	2008	2009	
Эмнэлгийн орны тоо	3970	3983	4005	3986
Их эмчийн тоо	1169	1232	1183	1195
Сувилагчийн тоо	1790	1878	1875	1848
Дундаж ор хоног	10.6	10.5	10.2	10.4
Хоног болоогүй нас баралтын хувь	22.4	21.9	19.8	21.4
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	125 850	128 873	131 068	128 597
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1 050 966	1 116 979	1 191 925	1 119 957
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн тоо /хөдөөнөөс/	31,802	34,498	30,727	32,342

Сүүлийн 3 жилд дунджаар улсын эмнэлэг болон төрөлжсөн төвүүдэд 128 мянган хүн хэвтэн эмчлүүлж байгаагийн 25-30 хувийг хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2007 онтой харьцуулбал 2009 онд нийт хэвтэн эмчлүүлэгчид 13.4 хувиар нэмэгдэж, харин хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгч 3.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 4.4.1 Гуравдагч шатлалын эмнэлгүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь



**Хүснэгт 4.4.3 Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдийн үйл ажиллагааны зарим
үр дүнгийн үзүүлэлтүүд**


Эмнэлгүүдийн нэр	Амбулаторийн үзлэгийн тоо	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт
УКТЭ	177361	20432	8,9	26,0
Клиникийн нэгдсэн II	96150	6786	9,1	20,0
Клиникийн нэгдсэн III	133686	15653	8,9	15,5
ЭНЭШТөв	163399	33099	6,5	15,9
Хавдар судлалын төв	72007	6660	9,7	1,6
ХӨСҮТ	104165	11043	15,0	17,3
ГССЗКЭмнэлэг	74626	11183	13,4	28,9
АӨСТөв	86975	4986	10,8	0,0
СЭМҮТ	43460	5885	27,8	9,1
Нялхасын клиникийн сувилал	-	314	8,0	-
УАШУТУКорпораци	20356	3305	9,8	-
Шүүх эмнэлэг магадлах товчоо	13808	-	-	-

БҮЛЭГ 5. ТОМУУГИЙН А (H1N1) ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ


Монгол улсад томуугийн цартахлын А (H1N1) вирусийн халдварын анхны тохиолдол 2009 оны 10 сарын 12 –нд бүртгэгдсэнээр Монгол улс томуугийн А (H1N1) вирусийн халдвар тархсан дэлхийн 197 дах орон болсон.

Монгол улсын хувьд томуугийн цартахлын А (H1N1) вирусийн халдварын анхны давалгаа нь улирлын томуугийн дэгдэлтэй давхцсан онцлог байсан. 2009 онд (10 000 хүн амд)-ийн томуу, томуу төст өвчний 7 хоногийн өвчлөлийн түвшин улирлын томуугийн 42 дахь 7 хоногт огцом нэмэгдэж, 43, 44 дэх долоо хоногт хамгийн оргил үедээ хүрсэн байна. /Зураг 2-оос харна уу./

Зураг 5.1 Бүртгэгдсэн ТТӨ-ийн өвчлөл 10 000 хүн амд




Зураг 5.2 Томуугийн A (H1N1)v вирусийн халдвартын тархалт



Насны бүлгээр авч үзвэл 0-4 нас 248 (19.9%), 5-9 нас 175 (14.0%), 10-19 нас 296 (23.7%), 20-59 нас 514 (41.2%), 60-аас дээш 15 (1.2%) тус тус эзлэж байна.

Зураг 5.3 Томуугийн A (H1N1)v вирусийн халдвартын тархалт (насны бүлгээр)




Монгол улсын хувьд томуугийн цартахлын A (H1N1) вирусийн халдвартын нас баралтын лабораториор батлагдсан анхны тохиолдол 2009 оны 10 сарын 21 өдөр буюу халдвартын анхны тохиолдол бүртгэгдснээс хойш 10 хоногийн дараа бүртгэгдсэн байна.

2010 оны 1 дүгээр сарын 3-ны байдлаар Томуугийн A (H1N1) вирусийн халдвартын шалтгаантай 28 нас баралт бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод-14, Өвөрхангай аймагт- 5, Өмнөговь, Дорнговь аймагт тус бүр 2, Булган, Архангай, Сүхбаатар, Дундговь, Баян-Өлгий аймагт тус бүр 1 байна.


Түүнчлэн 2010 оны 1 дүгээр сарын 3-ны байдлаар томуугийн цартахлын A (H1N1) вирусийн халдвартын нас баралтын хувь 2.2 байна. Монгол улсын хувьд улирлын томуугийн нас баралт сүүлийн жилүүдэд бүртгэгдээгүй бөгөөд нас баралтын хувь маш бага 0.01 хувьтай гэсэн судалгааны дүн байдаг.

ДЭМБ-ын мэдээлснээр 2009 оны 12 сарын 27-ны байдлаар дэлхийн 208 оронд томуугийн цартахлын A (H1N1) вирусийн халдвартын лабораториор батлагдсан тохиолдлын 12220 нас баралт бүртгэгдсэн байна. (Зураг 3) Зүүн Азийн улс орнуудад ерөнхийдөө томуугийн тархалт багасах хандлагатай байна. Томуу, томуу төст өвчний өвчлөл Япон, Хятадын Хойд, Өмнөд хэсэг, Тайпей, Монгол, Хонг-Конг одоогийн хүртэл хандлага үргэлжилж, харин Хойд Азийн улс орнуудад, Энэтхэгийн хойд хэсэг, Балба, Шриланк улсад томуугийн идэвхжил нэмэгдэх хандлагатай байна. (Зураг 4)

**Зураг 5.4 Томуу, томуу төст өвчний хандлага
Дэлхий дахинд**



**Зураг 5.5 Томуугийн A (H1N1)v (цартахлын)
вирусын халдвартын Дэлхий дахины тархалт**



БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН

6.1 Нийт халдварт өвчин

2009 онд улсын хэмжээнд 35 төрлийн цочмог халдварт өвчний 38859 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 4934 тохиолдол буюу 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл 18.6-аар буурсан байна. 21 аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдсэн цочмог халдварт өвчний 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Орхон аймагт 11.5, Баянхонгор аймагт 109.2-оор нэмэгдэж, бусад аймаг Улаанбаатар хотод буурсан үзүүлэлттэй байна. Энэ онд гар-хөл-амны өвчин, вируст хепатит, хүнсний гаралтай бактерит хордлого, салхин цэцэг өвчний 10 000 хүн амд ногдох өвчлөл 1.6-13.3-аар буурсан нь халдварт өвчний бууралтанд нөлөөлсөн байна.

2009 онд бүртгэгдсэн цочмог халдварт өвчин Баянхонгор, Булган, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд, Улаанбаатар хотод улсын дундажаас /10 000 хүн амд 146.2/ өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 47.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн.

2009 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчнүүдийн 43.8 хувь нь бэлгийн замаар дамжих халдвар, 17.7 хувь нь вируст хепатит, 10.8 хувь нь сүрьеэ, 9.4 хувь нь гэдэсний халдварт өвчнүүд, 10.0 хувийг нь амьсгалын замын халдвар, 8.3 хувь бусад халдвар тус тус эзэлж байна.

Зураг 6.1 2009 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц



2009 онд цочмог халдварт өвчний шалтгаант нас бааралтын 133 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 32 тохиолдлоор буурсан. Нийт нас бааралтын 75.9 хувь сүрьеэ, 15.0 хувь вируст хепатит, 3.0 хувийг менингококт халдварын шалтгаант нас бааралт эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад сүрьеэ өвчний шалтгаант нас бааралт 5 тохиолдлоор, вируст хепатит, менингококт халдварын шалтгаант нас бааралт тус бүр 7 тохиолдлоор буурсан.

6.2. Гэдэсний халдварт

2009 онд улсын хэмжээнд вируст хепатит А, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллын халдварт, балнад, суулгалт халдварт, гар хөл амны өвчин зэрэг 7 төрлийн гэдэсний халдварт өвчний 9543 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 24.6 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний 4546 (47.6%) нь Улаанбаатар хотод гарсан байна.


Гэдэсний замын халдварт өвчний 61.7 хувийг вируст хепатит А, 32.5 хувийг цусан суулга, 2.8 хувийг гар хөл амны өвчин, 1.3 хувийг хүнсний гаралтай бактерт хордлого, 1.3 хувийг сальмонеллээс, 0.5 хувийг суулгалт халдварт, 0.07 хувийг балнад тус тус эзэлж байна.

6.2.1. Вируст хепатит

Улсын хэмжээнд вируст хепатит өвчний 6865 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 17.2 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 3539 тохиолдлоор буурсан. Нийт вируст хепатитын өвчлөлийн 85.7 хувийг вируст хепатит А, 10.9 хувь вируст хепатит В, 1.9 хувийг вируст хепатит С, 1.5 хувийг бусад вируст хепатит тус тус эзэлж байна.

Вируст хепатитын 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл улсын дундаж 25.8 байна. Баян-Өлгий, Булган, Дорноговь, Орхон, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудын өвчлөл улсын дундажаас 14.2-50.6-аар өндөр байгаа бөгөөд 10000 хүн амд ногдох өвчлөлөөр хамгийн өндөр байгаа Сүхбаатар аймагт (10 000 хүн амд 76.4) 424 тохиолдол бүртгэгдэж 54.7 хувь нь аймгийн төвд илэрсэн. Вируст хепатит өвчнийг нийгмийн байдлаар авч үзвэл өвчлөгсдийн 37.9 хувь сурагчид, 18.9 хувь цэцэрлэгийн хүүхэд, 19.5 хувь гэрийн хүүхэд, 7.6 хувь ажилгүйчүүд, 6.4 хувийг оюутнууд тус тус эзэлж байна. Вируст хепатит А өвчнөөр 0-9 насны хүүхдүүд, вируст хепатит В өвчнөөр 15-29, вируст хепатит С 20-39 насны хүмүүс зонхилон өвчиж байна.

Зураг 6.2.1. Вируст хепатитийн өвчлөл, нас баралт, хандлага, 1999-2009



6.2.3. Балнад

2009 онд улсын хэмжээнд балнад өвчний 7 тохиолдол (Дархан Уул аймагт 3, Төв аймаг, Улаанбаатар хотод тус бүр 2) бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 0.02 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулбал 2 тохиолдлоор нэмэгдсэн.

6.2.4. Хүнсний гаралтай бактерт хордлого

2009 онд Улаанбаатар хотод хүнсний гаралтай бактерт хордлогын 92 тохиолдол, Архангай 8, Дархан-Уул 12, Дорнод 5, Өвөрхангай 4, Хөвсгөл 2 тохиолдол нийт 123 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 715 тохиолдлоор буурсан. Хоолны хордлогот халдвараар өвчлөгсдийн 43 хувийг нь ажилчин, сургуулийн сурагчид эзэлж байна.

6.2.5. Халдварын гаралтай суулгалт халдвар

Баянхонгор (24), Орхон (16), Дорнод (4), Дархан-Уул (2) аймгуудад нийт 46 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн онтой харьцуулахад 10 тохиолдлоор нэмэгдсэн (10 000 хүн амд 0.2) байна.

6.2.6. Цусан суулга

2009 онд улсын хэмжээнд цусан суулгын 3099 тохиолдол (10 000 хүн амд 11.7) бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 746 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн халдварын 76,8 хувь нь Улаанбаатар хотод гарсан байна.

Цусан суулга өвчний 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөлөөрөө Говьсүмбэр, Дорноговь аймаг, Улаанбаатар хотод улсын дундажаас 4.1-6.3-аар их байна.

Цусан суулга өвчнөөр өвчлөгсдийн 1441 нь эрэгтэй, 1658 нь эмэгтэй байгаа бөгөөд насны хувьд 0-3 насны хүүхдүүд илүү өртсөн ба 49.9 хувийг эзэлж байна

6.3. Амьсгалын замын цочмог халдвар


Амьсгалын замын зарим цочмог халдварт өвчний 3892 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 10.0 хувийг эзэлж, өвчлөлийн дотор салхинцэцэг (42.5%), гахай хавдар (51.1%) -ын халдвар зонхилох хувийг эзэлж байна. 10000 хүн амд 14.6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 816 тохиолдлоор ихэссэн үзүүлэлттэй ба өмнөх оноос гахайн хавдар 1430, ёлом 7 тохиолдлоор тус тус ихсэж, салхинцэцэг 407, менингококт халдвар 33, улаан эсэргэнэ 2, улаанбурхан 22, улаанууд 158 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна

6.3.1. Сүрьеэ

Сүрьеэ өвчний нийт 4218 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 10.9 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 2390 тохиолдол байгаа нь сүрьеэгийн нийт өвчлөлийн 56.7 хувийг эзэлж байна.

Ушигны түрхэц эерэг шинэ сүрьеэ 1809 бүртгэгдсэн нь урьд онтой харьцуулахад 29 тохиолдлоор буурсан байна.

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 60.1 хувийг ушигны сүрьеэ, 39.9 хувийг бусад эрхтний сүрьеэ эзэлж, хүүхдийн сүрьеэ 436 тохиолдол илэрсэн ба энэ нь сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын дотор 10.3 хувийг эзэлж байна.

Зураг 6.3.2.. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын хандлага 1999-2009 он

Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл:

16-44 насныхан 71.4 хувь байгаа нь залуу хөдөлмөрийн насын хүмүүс илүүтэй өвчилж байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 50.9 хувь, эмэгтэйчүүд 49.1 хувь, хүйсний харьцаа (эр: эм) = 1.0:1.0 байна. 2009 оны байдлаар оношийн баталгаажилт 74.1 хувь, эдгэрэлтийн түвшин 84.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оношийн баталгаажилт 2.3 хувиар, эдгэрэлтийн түвшин 0.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

6.3.3. Менингококкийн халдварт

2009 онд улсын хэмжээнд менингококт халдвартын 38 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд 0.1 тохиолдол ногдож байна. Өмнөх онтой харьцуулахад 33 тохиолдлоор буюу 10 000 хүн амд 0.2 -оор буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн менингококт халдвартын өвчлөлийн 28.95 хувь нь Нийслэл хотын хүн амын дунд бүртгэгджээ.

Менингококт халдварт бүх насныхан өртөж байгаа боловч 0-19 насныхны дунд өвчлөл өндөр байгаа бөгөөд нийт тохиолдлын 84.2 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд 52.6 хувь нь эмэгтэй, 47.4 хувь нь эрэгтэйчүүд байна.

Менингококт халдвартын шалтгаант нас баралтын 4 тохиолдол бүртгэгдснээс Өмнөговь аймагт 2, Увс аймаг, Улаанбаатар хотод тус бүр 1 тохиолдол байна. Менингококт халдвартын шалтгаант нас баралт өнгөрсөн оны мөн үеэс 7 тохиолдлоор буурсан байна.

6.3.2. Гахай хавдар

Улсын хэмжээнд 2009 онд гахайн хавдрын өвчлөлийн нийт 1990 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөл 7.5 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1430 тохиолдол буюу 10 000 хүн амд 5.4-аар нэмэгдсэн байна. 2009 онд Баян-Өлгий, Ховд аймгуудад гахайн хавдрын өвчлөл бүртгэгдээгүй байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гахайн хавдар өвчлөлийн 72.1 хувь нь Улаанбаатар хотын хүн амын дунд бүртгэгджээ. Нийт бүртгэгдсэн гахайн хавдрын өвчлөлд 0-19 насныхан илүүтэй өртөн (1646), үүнээс 40.9 хувь нь сурагчдын дунд зонхилон тохиолдсон байна. Гахайн хавдраар өвчлөгсдийн 54.5 хувь нь эрэгтэй, 45.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

6.3.3. Салхин цэцэг

Улсын хэмжээнд 2009 онд салхин цэцэг өвчний өвчлөл нийт 1654 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөл 6.2 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 407 тохиолдоор буурсан байна.

2009 онд салхин цэцэг өвчний 10 000 хүн амд ногдох өвчлөл нь Дорнод (28.4), Дорноговь (12.7), Увс (20.9), Ховд (12.3) аймгуудад улсын болон сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад өндөр байна.

6.3.4. Улаан эсэргэнэ

Улсын хэмжээнд 2009 онд улаан эсэргэнэ өвчний нийт 20 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөл 0.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдоор буурсан. 2009 онд улаан эсэргэний өвчлөл Дархан-Уул аймагт 1, Хэнтий аймагт 2, Улаанбаатар хотод 17 (10000 хүн амд 0.2) бүртгэгдэж, бусад аймгуудад бүртгэгдээгүй байна.

6.3.5. Улаанууд

5 аймаг, Улаанбаатар хотод улаанууд өвчний 9 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 0.03 ногдож байгаа нь өмнөх оноос 158 тохиолдоор буурсан байна. 2009 онд Булган (1), Дархан-Уул (1), Дундговь (2), Завхан (1), Өвөрхангай (1), Улаанбаатар (3) аймаг, хотуудад тус тус бүртгэгдэж, бусад аймгуудад өвчлөл бүртгэгдээгүй байна.

6.4 Бэлгийн замаар дамжих халдварт

БЗДХалдварт өвчний 17029 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 43.8 хувийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 619 тохиолдоор буурсан байна. БЗДХ-ын дотор трихомониаз 33.9 хувь, заг хүйтэн 37.3 хувь, тэмбүү 28.8 хувийг тус тус эзэлж байна. 10 000 хүн амд ногдох өвчлөлийг авч үзвэл: тэмбүү 18.5, заг хүйтэн 23.9, трихомониаз 21.7 болж, тэмбүү, трихомониазын 10 000 хүн амд ногдох өвчлөл нь өнгөрсөн оны мөн үеэс 0.2-2.9-оор буурч, заг хүйтэн өвчний өвчлөл 0.8-аар нэмэгдсэн байна.

2009 онд төрөлхийн тэмбүүгийн 19 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 2 тохилдоор нэмэгдсэн байна. Төрөлхийн тэмбүүгийн өвчлөл Өвөрхангай аймагт 7, Орхон аймагт 4, Дорноговь аймагт 3, Баянхонгор аймагт 1, Улаанбаатар хотод 4 тохиолдол тус тус бүртгэгдсэн болно.

Улаанбаатар хотод ХДХВ-ийн халдварын 13 тохиолдол бүртгэгдэж, насны бүлгээр авч үзвэл 15-44 насны хүмүүс байна.


2009 онд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн 70867 үзлэгийн дүнгээс үзвэл тэмбүү 1423 (2.0%), заг хүйтэн 837 (1.2%), трихомониаз 1508 (2.1%) тус тус илэрсэн байна.

БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

7.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

Тархвар зүйн шилжилтийн улмаас 1990 оноос эхлэн хүн амын өвчлөл, эндэгдлийн шалтгааны бүтцэд өөрчлөлт орж, “Дадал зурсил, зан үйлээс хамааралт” нэр авсан цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хорт хавдар, осол гэмтлийн шалтгаант өвчлөл давамгайлах болсон билээ

Хүснэгт 7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10000 хүн амд (2003-2009)



2009 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд:

- Амьсгалын тогтолцооны өвчин /10 000 хүн амд 1027.73/
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин /10 000 хүн амд 900.51/
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд.756.4/
- Зүрх-судасны тогтолцооны өвчин /10 000 хүн амд 679.44/
- Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин /10 000 хүн амд 416.91/ орж байна.

2009 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршилаар авч үзвэл УБ хотод хоол боловсруулах өвчин, амьсгалын тогтолцооны өвчин, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин, хөдөөд амьсгалын, хоол боловсруулах, шээс бэлгийн тогтолцооны өвчин тэргүүлэх 3 шалтгаанд орж байна. Тухайлбал 10000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчин хотод 860.15, хөдөөд 1140.85, хоол боловсруулах тогтолцооны өвчин хотод 880.07, хөдөөд 914.30, шээс бэлгийн тогтолцооны өвчин хотод 631.00, хөдөөд 841.05, осол гэмтлийн шалтгаант өвчлөл хотод 763.31, хөдөөд 183.07, зүрх-судасны тогтолцооны өвчин хотод 679.77, хөдөөд 679.21 ногдож байна.

2009 оны байдлаар 10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 1027.73, хоол боловсруулах тогтолцооны өвчин 900.51, шээс бэлгийн тогтолцооны өвчин 756.40, зүрх- судасны тогтолцооны өвчин 679.44, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин 416.91 ногдох байгаа бөгөөд 2000 онтой харьцуулахад 1.5-2 дахин нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 10 жилд эдгээр өвчлөлийн түвшин буураагүй тогтвортой нэмэгдсэнийг харуулж байна. (Зураг)

Хүснэгт 7.1.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2009 оны байдлаар

Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг
Хүйс					
Эрэгтэй	4700.35	987.19	745.77	352.91	527.84
Эмэгтэй	7219.42	1066.45	1048.31	1141.80	824.24
Насны бүлэг					
20 хүртэл	4555.52	1785.21	765.06	248.39	50.33
20-44	5528.01	473.29	719.77	1021.19	377.71
45-65	9116.25	69.15	1524.37	1196.18	2088.00
65 ба түүнээс дээш	13663.93	1129.49	1914.84	1226.40	4706.02
Байршил					
Хот	6600.99	860.15	880.07	631.00	679.77
Хөдөө	5575.45	1140.85	914.30	841.05	679.21
Бүсээр					
Баруун	4648.68	958.14	726.91	792.45	585.88
Хангайн	5738.44	1057.13	939.42	896.32	738.16
Төв	6342.08	1448.23	1001.75	902.86	819.87
Зүүн	5981.71	1373.92	1124.07	694.7	500.30
Улсын дүн	5988.75	1027.73	900.51	756.40	679.44
					416.91

10 000 эмэгтэй хүн амд ногдох амбулаторит бүртгэгдсэн өвчлөлийн түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад 1.5 дахин их байна. Өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл эрэгтэйчүүд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг улмаас амбулаторит үзүүлж, эмчлүүлсэн өвчлөлийн түвшин эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин их, бусад өвчлөлийн тэргүүлэх шалтгаан хувьд өвчлөлийн түвшин 1.5-3 дахин бага байна.

Хүн амын өвчлөлийг бүс нутгаар авч үзвэл баруун бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (958.14), шээс бэлгийн тогтолцооны өвчин (792.45), хоол боловсруулах тогтолцооны өвчин (726.91), хангайн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (1057.13), хоол боловсруулах тогтолцооны өвчин (939.42), шээс бэлгийн тогтолцооны өвчин (896.32), төвийн болон зүүн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (1284.48 ба 1197.27), хоол боловсруулах тогтолцооны өвчин (918.17 ба 1002.81), шээс бэлгийн тогтолцооны өвчин (883.63 ба 658.02) тэргүүлэх 3 шалтгаанд орж байна.

Нөгөөтэйгүүр амьсгалын тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, хоол боловсруулах тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, шээс бэлгийн тогтолцооны өвчин баруун, хангай.govийн болон төвийн бүсэд, зүрх-судасны тогтолцооны өвчин төвийн болон хангайн бүсэд, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин төвийн болон зүүн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.

2009 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд

- Амьсгалын тогтолцооны өвчин / 10000 хүн амд 338.14/
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин / 10000 хүн амд 337.26/
- Зүрх-судасны тогтолцооны өвчин / 10000 хүн амд 328.28/
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин / 10000 хүн амд 312.12 /
- Мэдрэлийн тогтолцооны өвчин / 10000 хүн амд 175.20/ орж байна.

Хүснэгт 7.1.2 Стационарын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2009 оны байдлаар

Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Зүрх- судасны тогтолцооны өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин
Хүйс					
Эрэгтэй	1761.36	344.72	305.61	166.80	269.37
Эмэгтэй	3003.19	331.85	367.50	450.93	384.56
Насны бүлэг					
20 хүртэл	1528.94	603.44	241.72	111.30	25.09
20-44	2358.39	129.49	267.64	380.73	153.97
45-65	3618.33	223.77	634.12	523.89	986.23
65 ба түүнээс дээш	6798.23	511.08	927.25	741.47	2650.83
Байршил					
Хот	2672.55	329.21	398.07	268.63	347.36
Хөдөө	2210.16	344.16	296.22	341.48	315.40
Бүсээр					
Баруун	2352.00	368.39	331.44	392.88	330.36
Хангайн	2117.37	277.96	290.61	336.81	331.26
Төв	2302.43	398.35	291.52	333.59	348.50
Зүүн	2309.21	398.86	309.70	285.69	257.24
Улсын дүн	2396.50	338.14	337.26	312.12	328.28
					175.20

Эмнэлэгт хэвтэлтийн түвшин 10 000 эрэгтэй хүн амд 1761.36, 10 000 эмэгтэй хүн амд 3003.19 ногдох байгаа эмнэлэгт хэвтэж байгаа 3 хүний нэг нь эрэгтэйчүүд байна .

10000 эрэгтэй хүн амд ногдох стационарын өвчлөлийн түвшин 10000 эмэгтэй хүн амд ногдох стационарын өвчлөлийн түвшинээс 1.5 дахин бага байна.

Хүснэгт 7.1.3 Стационарт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин 10000 хүн амд, 2009 он

Өвчний ангилал (ӨОУА-10)	Сумын хүн амын өвчлөл	Аймгийн хүн амын өвчлөл	УБ хотын хүн амын өвчлөл	Нийт хүн амын өвчлөл
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	314.61	383.81	263.71	312.12
Амьсгалын тогтолцооны өвчин	290.64	431.92	323.19	338.14
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	182.49	486.81	390.79	337.26
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	262.93	401.45	341.01	328.28
Мэдрэлийн тогтолцооны өвчин	73.32	293.39	200.88	175.20
Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	34.00	134.42	125.04	93.97
Халдварт ба шимэгч зарим өвчин	28.81	157.25	88.33	82.01
Яс булчин холбох нэхдэсийн өвчин	51.85	110.24	93.61	82.44
Арьс ба халимны өвчин	41.64	102.27	71.02	67.55
Сэтгэцийн ба аягийн эмгэг	9.22	69.34	55.99	41.84
Хавдар	13.47	47.42	88.44	51.91
Нүд ба түүний дайврын өвчинүүд	2.00	36.97	49.64	29.34
Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчинүүд	12.13	28.44	28.67	22.66
Чих ба хөхөнцрийн өвчин	9.10	26.04	18.36	16.74
Бусад	200.66	677.39	484.98	417.04
Бүгд	1505.65	3387.17	2623.67	2396.50

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтцийг байршлын хувьд авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдаж байна. Жишээ нь: Сумын болон аймгийн хүн амын эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд шээс бэлгийн тогтолцооны болон хоол боловсруулах тогтолцооны өвчлөл орж байхад Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэж эмчлүүлэгчдийн тэргүүлэх шалтгаанд хоол боловсруулах болон зүрх-судасны тогтолцооны өвчлөлүүд тэргүүлж байна.

2009 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчинүүдийг авч үзвэл: Шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 69.1 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин 66.6, амьсгалын тогтолцооны өвчний дотор уушигны хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 38.3 хувийг, хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 25.7 хувийг, зүрх-судасны тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчин 34.4 хувийг, зүрхний ишеми өвчин 29.5 хувийг тус тус эзэлж байгаа нь эдгээр өвчинүүд хүн амын дунд зонхилон тохиолддогийг харуулж байна.

Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин нь 2000 онд шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 56.7 хувийг эзэлж байсан бол 2004 онд 65.4 хувь, 2009 онд 66.6 хувь болж, 2000 онтой харьцуулахад 2009 онд 10.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 7.1.4 Зонхилон тохиолдох стационарын өвчлөлийн бүтэц, хувиар, 2009 он

Өвчний ангилал (ӨОУА-10)	Зонхилох шалтгаан	Өвчлөлийн тухайн бүлэгт эзлэх хувь									
		2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Шээс бэлгийн тогтолцоо	Бэөрний сувганцрын үрэвсэл (N10-N16)	56.70	55.76	59.03	63.14	65.41	69.06	69.7	67.8	69.1	66.6
Амьсгалын тогтолцооны өвчин	Хатгалгаа (J12-J18)	46.75	42.69	41.01	42.67	43.24	39.83	38.6	40.5	41.9	38.8
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Элэгний эмгэг (K70.K73. K74.K71-K73. K75-K77)	18.90	19.30	21.52	21.82	23.73	25.66	24.9	25.1	25.6	25.7
	Мухар олгойн өвчин (K35-K38)	26.57	24.33	22.22	22.66	21.43	20.22	19.4	18.6	17.0	16.9
	Цөсний хүүдийн өвчинүүд (K80-K81)	14.64	14.50	14.92	16.45	15.84	15.57	15.3	13.97	13.7	14.2
Зүрх- судасны тогтолцооны өвчин	Даралт ихсэх өвчинүүд (I10.I11-I15)	34.66	34.66	34.44	32.64	32.3	31.30	32.6	32.1	33.2	34.4
	Зүрхний ишеми өвчинүүд (I20.I23-I25)	19.19	20.29	20.91	23.46	25.73	26.28	26.3	29.3	30.1	29.5
Мэдрэлийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг (G50-59)	18.09	19.21	19.71	20.92	20.5	23.40	21.7	22.1	24.3	26.0
	Эпилепси (G40-G41)	11.69	10.78	11.35	12.63	12.99	12.35	12.5	11.7	11.2	10.9

Уушгини хатгаа өвчин 2000 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 46.7 хувийг эзэлж байсан бол 2004 онд 43.2 хувь, 2009 онд 38.8 хувь болж, 2000 онтой харьцуулахад 2009 онд 8.0 хувиар буурсан байна.


2000 онд хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор 18.9 хувийг элэгний эмгэг, 14.6 хувийг цөсний өвчинүүд эзэлж байсан бол 2009 онд элэгний эмгэг нь 25.7 болон нэмэгдэж, харин цочмог мухар олгойн үрэвсэл өвчин 2000 онд 26.6 хувийг эзэлж байсан бол 2004 онд 21.3 хувь, 2009 онд 16.9 хувь болж буурсан байна.

Зүрхний ишеми өвчин нь 2000 онд зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 19.2 хувийг эзэлж байсан бол 2004 онд 25.7 хувь, 2009 онд 29.5 хувь болж, 2000 онтой харьцуулахад 2009 онд 10.2 хувиар нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

1995 оноос хойш хүн амын нас баралтын шалтгаанд зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант нас баралт тэргүүлэх 3 байруудыг эзэлж жил ирэх тутам эдгээр өвчиний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна.

Зураг 8.1. Нас баралтын зонхилох шалтгаан хүйсээр, 2009



2009 онд хүн амын нас баралтын шалтгааны 38.0 хувийг зүрх-судасны тогтолцооны өвчин, 20.8 хувийг хавдар, 15.2 хувийг гэмтэл, хордлого ба гадны шалтгаант өвчин эзэлж байгаа бөгөөд нийт нас баралтын шалтгааны 75 хувь ногдож байна.

Жилд дунджаар 5800 гаруй хүн буюу нас барсан гурван хүний нэг зүрх-судасны тогтолцооны өвчин, 3200 хүн буюу таван хүний нэг нь хавдар, 2300 хүн буюу 7 хүний нэг нь гэмтэл, хордлого ба гадны шалтгаант өвчиний улмаас нас барж байна.

2009 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд:

- Зүрх- судасны тогтолцооны өвчин (10000 хүн амд 21.74)
- Хавдар (10000 хүн амд 11.89)
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант өвчин (10000 хүн амд 8.71)
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин (10000 хүн амд 4.84)
- Амьсгалын тогтолцооны өвчин (10000 хүн амд 2.78) орж байна.

Хүн амын нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 69.11, 10 000 эмэгтэй хүн амд 45.99 ногдож байна.

ДЭМБ-аас 2008 оны тооцоолсноор 2030 оны нас баралтын хэтийн төлөвийг дэлхийн хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан нь зүрхний ишемийн өвчин, тархины судасны өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин, амьсгалын доод замын халдвартууд, замын осол гэмтэл байх тооцоо гарчээ. (Хүснэгт 8.3)

